

Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын үйл ажиллагааны товч мэдээлэл

Д/д	Яам	Сарын онцлох ажил	Тулгамдсан болон хойшлогдож байгаа ажил
1	ГХЯ	<p>1. Япон Улсын Ерөнхий сайдын Ш.Абэ-гийн манай улсад хийсэн албан ёсны айлчлалын бэлтгэлийг хангаж, амжилттай хэрэгжүүлэв.</p> <p>2. Данийн Парламентын дарга Могенс Ликкеттофт айлчлалынхаа хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржид бараалхаж, УИХ-ын дарга З.Энхболдтой албан ёсны уулзалт хийж, Гадаад харилцааны сайд Л.Болд, Уул уурхайн сайд Д.Ганхуяг нартай тус тус уулзсан болно.</p> <p>3. Их Британий Ерөнхий сайд асан Тони Блэйрын айлчлалын бэлтгэлийг хангаж хэрэгжүүлэв.</p>	<p>1. Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журамыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх.</p> <p>2. Япон Улсын Ерөнхий сайд Ш.Абэ, Туркийн Ерөнхий сайд Рэжэп Тайип Эрдоган нарын манай улсад хийсэн айлчлалын дүнгийн тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх.</p> <p>3. Үндэсний гадаад паспортын журмыг шинэчлэх тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх.</p>
2	ХЗЯ	<p>1. Эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> • “Цагдаагийн байгууллагын тухай” • “Мөрдөх албаны тухай” • “Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай” • “Маршалын албаны тухай” • “Гэрч хохирогчийн эрх зүйн байдлын тухай” • “Төлбөрийн чадваргүй яллагдагчид эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хуулийн төслүүдийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэв. <p>2. Хилийн шалган нэвтрүүлэх албаны иргэдийн баримт бичгийг шалгах асуудлыг боловсронгуй болгох ажлын хүрээнд Хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан УИХ-д өргөн мэдүүлэв.</p>	<p>1. “Монгол Улсын хууль тогтоомжийг 2016 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл”-ийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх.</p> <p>2. УИХ-ын 2013 оны хаврын чуулганаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Гэмт хэргийн тухай хууль -Гэмт хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль -Цагдаагийн албаны тухай хууль -Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хууль -Мөрдөх албаны тухай хууль -Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хууль -Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль -Маршалын албаны тухай хууль.
3	СЯ	<p>1. Сангийн сайдын 2013 оны 63 дугаар тушаалаар Улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд зориулан 2013 оны 2 дугаар улиралд гаргах Засгийн газрын үнэт цаасыг арилжаалах хуваарийг батлав. Нийт 515 тэрбум төгрөгний нэрлэсэн дүн бүхий үнэт цаасыг арилжаалахаар байна.</p> <p>2. Сангийн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгаалалын сайд, Монголбанкны Ерөнхийлөгч, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2013 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн А/30, А-60, 67 дугаар хамтарсан шийдвэрээр Нийгмийн даатгалын сангийн</p>	<p>1. Дархан-Уул аймгийн төсвийн орлогын бүрдүүлэлтэд хүндрэл учирч байгаа тул Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газарт 1.0 тэрбум төгрөгийн зээлийг улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгох тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх.</p> <p>2. Монгол Улсын төсөвт үүсч байгаа нэмэлт ачааллын талаар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх.</p>

		үлдэгдэл хөрөнгөөс 2013 онд арилжааны банкинд харилцах, хадгаламж хэлбэрээр байршуулах хөрөнгийн хэмжээг 400.0 /дөрвөн зуун/ тэрбум төгрөгөөр тогтоолоо.	
4	ЗТЯ	<p>1. "МИАТ" ТӨХК-д "Үндэсний агаарын тээвэрлэгч статус" олгох асуудлыг Засгийн газрын 2013 оны 72 дугаар тогтоол батлав.</p> <p>2. Хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар хэрэгжих болон шинээр эхлүүлэхээр төлөвлөөд байгаа нийт 1800 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын болон Зөвлөхийн үйлчилгээний ажилд шаардлагатай хөрөнгийн асуудлыг Эдийн засгийн хөгжлийн яам, Хөгжлийн банктай тохиролцсоны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 3 сарын 30-ны өдрийн хуралдаанаар шийдвэрлэлээ.</p>	<p>1. Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай УИХ-ын 2010 оны 32 дугаар тогтоолын 2 дахь заалтын 5-д заасан III үе шатанд баригдах хөндлөн болон баруун босоо чиглэлд тавих төмөр замын замнал /маршрут/-ыг нарийвчлан тодорхойлж УИХ-аар батлуулах.</p> <p>2. "Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв" улсын төсөвт үйлдвэрийн газрын барилгыг барих газрын асуудал, санхүүжилтийг шийдвэрлэх.</p> <p>3. Төмөр замын дээд сургуулийн нэрийг УБТЗ-ын даргын 2013.03.15-ны өдрийн 58 дугаар тушаалаар Тээврийн дээд сургууль болгон өөрчилсөн. Одоо бүтэц зохион байгуулалтыг өөрчилж, сургалтыг эхлүүлэх шаардлагатай.</p> <p>4. Богдхан төмөр замын зураг төслийн санхүүжилтийг шийдвэрлэх</p>
5	ХАХНХЯ	<p>1. "Хүн амын асуудлаарх Үндэсний зөвлөл байгуулах тухай" асуудлыг Засгийн газрын 2013 оны 97 дугаар тогтоолоор батлав.</p> <p>2. Хүүхэд, гэр бүлд асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээ үзүүлэх ТББ, аж ахуйн нэгж, иргэний мөрдөх дүрэм, Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох дүрэм, журмыг шинэчлэн боловсруулж, ХАХНХЯ-ны сайдын 2013 оны 28 тоот тушаалаар батлав.</p> <p>3. ХАХНХ-ын сайдын 2013 оны А/23 тоот тушаалаар Батсүмбэрийн Улсын асрамжийн газрын асрамжийн газрын нэрийг "Ахмадын асрамж, хөгжлийн үндэсний төв" болгон өөрчилж, тус төвийн орон тоо, бүтэц зохион байгуулалтыг шинэчлэн батлав.</p>	<p>1. "Ахмад мэргэжилтнүүдийн үндэсний сүлжээ байгуулж, тэдний мэдлэг, туршлагыг залуу үед өвлүүлэх үндэсний хөтөлбөр" боловсруулах.</p> <p>2. Сонсголын бэрхшээлтэй иргэдэд шуурхай тусламж мессэжээр (SMS) дуудлага өгөх, мэдээлэл авах үйлчилгээг нэвтрүүлэх .</p>
6	БХЯ	1. Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад үүрэг гүйцэтгэх II ээлжийн цэргийн багийн хоёрдугаар хэсгийн бүрэлдэхүүний ажиллагааны өмнөх бэлтгэлийг бүрэн хангуулж нийт бие бүрэлдэхүүнийг 3 дугаар сарын 01-ний өдрөөс 14-ний өдрүүдэд нийт 4 удаагийн нислэгээр ажиллагааны газар оронд амжилттай илгээсэн.	<p>1. "Монгол Улсын төрийн батлан хамгаалах бодлого" баримт бичгийг УИХ-аар батлуулах.</p> <p>2. "Цэрэг-техникийн салбарт хамтран ажиллах тухай" Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг батлах.</p> <p>3. "Зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого" боловсруулах.</p>

7	ЭЗХЯ	<p>1. Чингис бондын санхүүжүүлтээр 6 аймгийн төвийг Улаанбаатар хоттой холбох, гудамж төсөл, шинэ төмөр замын ажлыг эхлүүлэхээр шийдвэрлэв.</p> <p>2. БНХАУ-ын Засгийн газраас олгох экспортын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслүүдийн жагсаалтыг Засгийн газрын хуралдаанаар батлав.</p>	<p>1. “Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах .</p> <p>2. Дархан-Уул аймагт байгуулах газрын тосны үйлдвэрийн зээлийн гэрээг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлах.</p> <p>3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулж УИХ-д өргөн мэдүүлэх.</p> <p>4. Могойн голын дулааны цахилгаан станц төслийн концессын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах.</p> <p>5. Монгол Улсын хөрөнгө оруулалтын дунд хугацааны хөтөлбөрийн төслийг боловсруулж, хөрөнгө оруулалтын мэдээллийн сан бүрдүүлэх.</p>
8	ХЯ	<p>1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах, шалгалт авах журам”-ыг Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/53 тоот тушаалаар шинэчлэн батлав.</p> <p>2. БНАСАУ-аас 2013 онд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх ажиллах хүчний тоо хэмжээг эдийн салбар бүрээр харилцан тохиролцож баталгаажуулав.</p>	<p>1. “Хөдөлмөр Эрхлэлтийг Дэмжих Сангаас зээлийн эрсдэлийн болон баталгааны сан байгуулах журам”-ыг Засгийн газраар батлуулах.</p> <p>2. “Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын шинэчлэл”-ын хүрээнд Хөдөлмөрийн салбарын 2016 он хүртэлх хөгжлийн ерөнхий төсөөллийг боловсруулах.</p> <p>3. “Ажилтай, орлоготой Монгол хүн” Үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Засгийн газраар батлуулах.</p> <p>4. Жижиг Дунд Үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих чиглэлээр зээлийн давхар батлан даалт гаргах журам боловсруулах.</p>
9	БОНХЯ	<p>1. Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын А-85 тоот тушаалаар Ойжуулалт, ойг нөхөн сэргээх ажлын 1 га талбайн зураг төсөв хийх ажлын нормативыг батлав.</p> <p>2. Тусгай зориулалтаар 2013 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай, Ховор амьтан агнах, барих зөвшөөрөл олгох тухай журам, Агнуур зохион байгуулалтын мэргэжлийн байгууллагын ажиллах журмуудыг Засгийн газрын 2013 оны 93 дугаар тогтоолоор батлав.</p>	<p>1. Цаг агаарт зориудаар нэмэгдүүлэх үйл ажиллагаанд 2013 онд хэрэглэгдэх борооны пуужингийн лицензийг гаргуулах.</p> <p>2. Агаарын бохирдолыг бууруулах үндэсний хорооны ажлын хүрээнд Улаанбаатар хотын дөрвөн дүүрэгт агаарын бохирдлын явуулын судалгаа хийх.</p> <p>3. Богдхан уулын дархан цаазат газрын хязгаарлалтын бүсэд газар ашиглаж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллага, зөвшөөрөлгүй газар ашиглаж буй иргэдийн үйл ажиллагаанд шалгалт явуулж газар ашиглалтын байдлын хавсралт зураг, судалгааны материалыг боловсруулж холбогдох арга хэмжээ авах.</p>
10	ЭМЯ	<p>1. Эрүүл мэндийн сайдын 2013 оны 68 дугаар тушаалаар “Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам”, Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн</p>	<p>1. Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа хуулиудыг дагаж гарах эрх зүйн зарим актуудыг хавсралтад заасан хугацаанд боловсруулах.</p>

		үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журмуудыг тус тус батлав.	2. Яамны харьяа байгууллагуудын удирдлагуудын сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, томилох.
11	БХБЯ	1. Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага, хяналтыг сайжруулах, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх зорилго бүхий "Цэнхэр карт" хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Барилга, хот байгуулалтын сайд, Хөдөлмөрийн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалаар 3 дугаар сарын 22-ны өдөр батлав.	1. Орон сууцны санхүүжилтийн тогтолцоо, зээлийн механизмыг шинэчлэх талаар санал боловсруулах. 2. "Газрын тухай", "Газрын төлбөрийн тухай", "Газрын кадастрын тухай" хуулиудын шинэчилсэн найруулга, "Геодези, зураг зүйн тухай" хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, "Газар албадан чөлөөлөх тухай" хуулиудыг УИХ-аар батлуулах.
12	ЭХЯ	1. "Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотод баригдах гэр хорооллын инженерийн дэд бүтцийн барилга байгууламж, шугам сүлжээний ажлыг Хөгжлийн банкны санхүүжилтээр хийлгэхээр БХБЯ, НЗДТГ-тай хамтран ажиллаж, тус саналыг 2013 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар батлав.	1. "Эрчим хүчний зохицуулах хорооны дүрэм"-д нэмэлт, өөрчлөлт оруулах. 2. Багануур ХК-иас эрчим хүчний үйлдвэрлэлийн өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангахын тулд ойрын 3 жилд 145,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр шийдэх. 3. Эрчим хүчний салбарын үйлдвэр, компаниудын эдийн засгийн байдал, эрчим хүчний үнэ тарифтай холбоотой санхүүгийн хүндрэлийг шийдэх.
13	ССАЖЯ	1. Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалыг брэнд бүтээгдэхүүн бий болгох, гадаад дотоодын жуулчдын сонирхлыг татах зорилгоор: -Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд "Мөсний баяр", -Улаанбаатар хот Богд Уулын Жаргалантын аманд "Бүргэдийн баяр" -Өмнөговь аймгийн Булган суманд "Түмэн тэмээний баяр", -Төв аймгийн Сэргэлэн сумын Цонжин болдогт "Тэмээн поло-2013" зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулав.	1. Палеонтологи, археологийн музейн үзмэрийг гадаад улс, орноос цуглуулж авчрах, бүртгэх, судлан шинжлэх, Үлэг гүрвэлийн төв музей байгуулах. 2. "Аялал жуулчлалын тухай" хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах. 3. Соёл, урлагийг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг эцэслэн боловсруулж, батлах.
14	ҮХААЯ	1. Чингис бондоос ноолуурын салбарт 95 тэрбум хүртлэх төгрөгийн зээл олгох тухай Засгийн газрын тогтоол батлав. 2. "Стратегийн хүнсний экспорт, импротын зөвшөөрөл олгох тухай журам"-ыг Засгийн газрын 2013 оны 77 дугаар тогтоолоор батлав.	1. 2013 он хаврын тариалалтад шаардагдах цагаан арвай, рапсын үрийг импортоор авах. 2. Хөдөө аж ахуйн биржийг туршилтын журмаар ажиллуулж эхлүүлэх. 3. "Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах тухай журам"-ыг боловсруулж, батлах. 4. "Чингис хаан бонд"-ын эх үүсвэрээс санхүүжигдэх үйлдвэр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих төслүүдийг эцэслэн шийдвэрлэх. 5. "Төрийн өмчийг 2013-2016 онд хувьчлах, өөрчлөн

			байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон үзэл баримтлалын төслийг танилцуулгын хамт боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх.
15	УУЯ	1. Улсын төсвийн хөрөнгөөр геологи, хайгуулын ажил хийх зорилгоор стратегийн ач холбогдол бүхий Эрдэнэтийн ордын талбайнуудын талаар “Талбай нөөцөд авах, хайгуулын ажил хийх тухай” Засгийн газрын 2013 оны 98 дугаар тогтоол батлав.	1. Оюу толгойн хөрөнгө оруулалтын зардлын өсөлт, Оюу толгойн бүлэг ордын эзэмшилттэй холбоотой асуудлыг шийдэх. 2. Экспортод гарч байгаа нүүрсний борлуулалтын үнэлгээг тооцох аргачлалыг батлан мөрдүүлэх санал боловсруулах. 3. Монголын Геологийн Албаны бүтэц, зохион байгуулалтын төслийг боловсруулж, батлах.
16	БШУЯ	1. Герман-Монголын технологийн дээд сургууль байгуулах асуудлыг Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлэв. 2. Нийслэлийн 84 дүгээр сургуульд сүүлийн үеийн смарт тоног төхөөрөмж бүхий “E-class” танхимын нээлт боллоо. Энэ арга хэмжээ нь Монгол Улсад Смарт сургуулийг хөгжүүлэх эхний алхам юм.	1. “Монгол судлалыг дэмжих сан” байгуулах зорилгоор Тусгай сангийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийг УИХ-аар батлуулах. 2. Өндөр хөгжилтэй оронд Сургалтын төрийн сангийн зээлээр суралцан ирж гэрээний үүргээ биелүүлэн улсад 5, түүнээс дээш жил ажилласан иргэдийг зээлээс чөлөөлөх асуудлыг шийдэх. 3. Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн “Зөв монгол хүүхэд” хөтөлбөрийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд оруулах.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР